



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

Улсын Их Хурлын тамгын газрын 1 дүгээр байр,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/факс: (976-51) 26 45 36,  
Цахим шуудан: prd.institute@parliament.mn,  
Цахим хуудас: www.research.parliament.mn

2026.03.05 № 110-01/0076

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Д.БУМ-ОЧИР ТАНАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайланг үүгээр хүргүүлж байна.

Хувийг: Улсын Их Хурлын Тамгын газарт

ЗАХИРАЛ

Д.ОНОЛТ



1526030031



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН  
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Судалгааны төрөл:  
Судалгааны код:  
Хугацаа:

Зардлын тооцоо  
ЗТ-26/102  
2026-03-05

ЗАХИАЛАГЧ:

УИХ-ын гишүүн Д.Бум-Очир

Хянасан:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр (Ph.D)

Судалгааны хэлтсийн дарга Э.Дашзэгвэ

Судалгаа удирдсан:

Судалгааны хэлтсийн зөвлөх Б.Оюун-Эрдэнэ

Судлаач:

Б.Мөнхзориг

## АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	ii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	ii
УДИРТГАЛ.....	3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО .....	4
1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо.....	4
2. Иргэний зардлын тооцоо.....	4
3. Төрийн байгууллагын зардлын тооцоо.....	4
3.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа.....	4
3.2. Хүний нөөцийг тодорхойлох .....	8
3.3. Нэмэгдэх ажлын ачаалал.....	13
3.4. Гарах зардлыг урьдчилан тооцох.....	18
3.5. Нийт зардлыг тооцох.....	21
3.6. Хялбарчлах боломжийг шалгах.....	21
ДҮГНЭЛТ .....	23
АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	24
ХАВСРАЛТ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ 2026 ОНЫ 02 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН 3/98 ТООТ АЛБАН БИЧГИЙН ХУУЛБАР .....	25
ХАВСРАЛТ 2. ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ 2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН 03/933 ТООТ АЛБАН БИЧГИЙН ХУУЛБАР.....	28

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төрийн байгууллагын үүрэг, стандарт үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ .....	5
Хүснэгт 2. Хүний нөөцийн хэрэгцээ .....	8
Хүснэгт 3. Нэг жилд шаардагдах хугацаа ба нэмэгдэх ажлын ачаалал.....	13
Хүснэгт 4. ДТГ байрладаггүй гадаад улс, хотод сонгууль зохион байгуулах салбар комисс байгуулах дундаж зардал.....	19
Хүснэгт 5. Салбар комисст санал тоолох төхөөрөмжийг ашиглах дундаж зардал .....	20
Хүснэгт 6. Сонгуулийн хэсгийн хорооны дундаж зардал .....	20
Хүснэгт 7. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал.....	21
Хүснэгт 8. Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчдын зардал, 2026-2027 .....	21

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ГХЯ	Гадаад харилцааны яам
ХО	Хөрөнгө оруулалт

## УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргана” гэж заасан байдаг. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” (цаашид “аргачлал” гэх)-ыг баримтлан Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа дараах харилцааг голлон зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

1. Гадаад улсад байгаа иргэд санал өгөхдөө урьдчилан бүртгүүлэхгүй бөгөөд сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал өгөх боломжийг бүрдүүлэх, сонгууль зохион байгуулах өдрөөс өмнө 5 хоногийн хугацаанд урьдчилсан санал авах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

2. Санал авах өдөр саналаа өгөх боломжгүй сонгогчийн саналыг урьдчилан авах төрөл, хэлбэрийг нэвтрүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх.

3. Санал авах өдөр тухайн сонгогч өөрийн харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжгүй тохиолдолд өөр аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн сонгуулийн хэсгийн хорооны дэргэдэх тусгай санал авах байранд саналаа өгөх боломжийг хангахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

**Судалгааны зорилго:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын хэмжээ, цаг хугацааны ачааллыг тооцож, төсөвт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

**Судалгааны ажлын бүтэц:** Хуулийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, зардлын тооцоог дараах агуулгын хүрээнд боловсруулав. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо;
2. Иргэнд үүсэх зардлын тооцоо;
3. Төрийн байгууллагын зардлын тооцоо.

**Судалгааны арга зүй:** Зардлын тооцооллыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгэсэн.

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

## 1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо

Хуулийн төсөл болон үзэл баримтлалын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийхэд, уг хуулийн төсөл хэрэгжсэнээр хуулийн этгээд (аж ахуйн нэгж, компани)-д шинээр хүлээх үүрэг үүсэхгүй байна. Учир нь хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар энэхүү нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн дараах харилцааг зохицуулахад чиглэсэн байна:

- Сонгогчийн сонгох эрхийг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх
- Гадаад улсад байгаа иргэд болон байнгын оршин суугаа газраасаа өөр газар байгаа иргэдийн санал авах ажиллагааг зохион байгуулах
- Сонгуулийн зохион байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Өөрөөр хэлбэл, уг хуулийн төсөл нь сонгуулийн зохион байгуулалтын шинжтэй бөгөөд "хуулийн этгээд"-ийн үйл ажиллагаа, тэдгээрт хүлээлгэх захиргааны болон санхүүгийн ямар нэгэн шинэ үүрэг, зохицуулалтыг агуулаагүй байна. Хуулийн төсөл батлагдсанаар гарах үр дагаврыг "сонгогчийн сонгох эрхээ хэрэгжүүлэх нөхцөл боломж нэмэгдэнэ" хэмээн тодорхойлсон байна.

## 2. Иргэний зардлын тооцоо

Хуулийн төсөл нь иргэдэд (оюутан, уртын ээлжээр ажиллагчид, гадаадад байгаа иргэд гэх мэт) саналаа өгөх боломжит хувилбаруудыг буюу урьдчилан санал өгөх, өөрийн харьяаллын бус хэсэгт санал өгөх боломжуудыг бий болгож байна. Хуулийн төсөл хэрэгжсэнээр өмнө нь зохион байгуулалтын бэрхшээлээс шалтгаалан сонгох эрхээ бүрэн эдэлж чадахгүй байсан нийт 250,000 орчим иргэнд санал өгөх боломж нээгдэхээр байна. Үүнд, гадаад улсад байгаа 120,000 орчим иргэд, улирлын шинж чанартай ажил эрхэлдэг ажиллагчид 56,000 орчим, оюутан залуус 20,000 орчим, сонгууль зохион байгуулахад оролцдог төрийн албан хаагчид 46,000 орчим, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон үүрэг гүйцэтгэж буй бусад албан хаагчид 8000 орчим байдаг байна.

Хуулийн төсөл нь сонгогчид ирэх ачааллыг бууруулах чиглэлд 1) бүртгэлийн дарамтгүй болох буюу гадаад улсад байгаа иргэд санал өгөхийн тулд заавал урьдчилан бүртгүүлэх шаардлагагүй болох, 2) санал авах байранд биеэр очих боломжгүй иргэд санал авах өдрийн өмнөх 3 хоногт урьдчилан саналаа өгөх боломжтой болж хугацааны хувьд уян хатан болох, 3) орон зайн хязгаарлалт арилж, сонгогч өөрийн харьяа газраас өөр газарт байгаа тохиолдолд тухайн байгаа газрынхаа Сонгуулийн хорооны дэргэдэх тусгайлан бэлтгэсэн байранд санал өгөх, 4) гадаадад байгаа иргэдийн санал авах хугацааг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш тогтоож байхаар зохицуулах замаар мэдээлэлд суурилсан сонголт хийх боломжтой болох өөрчлөлтүүдийг тусгасан байна. Иймд, сонгуулийн хууль тогтоомжид туссан эрх нь хангагдаж, сонгууль өгөх боломж нэмэгдэж байгаа тул иргэнд нэмэлт зардал, ачаалал үүсэхгүй гэж үзлээ.

## 3. Төрийн байгууллагын зардлын тооцоо

### 3.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комисс, Сонгуулийн ерөнхий хороо болон хэсгийн хороодын

үйл ажиллагаанд ачаалал нэмэгдэх, зардал гарах шаардлагатай зарим нэмэлт үүргүүд үүсэж байгаа бөгөөд тэдгээрт хамаарах стандарт үйл ажиллагааг Хүснэгт 1-т харууллаа. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 46.1-т заасны дагуу УИХ-ын холбогдох Байнгын хороо Тамгын газартай хамтран хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах нийтлэг үүргийг тусгав.

**Хүснэгт 1. Төрийн байгууллагын үүрэг, стандарт үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ**

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Ерөнхий үйл ажиллагаа	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа (мин)
Улсын Их Хурал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200
			Мэдээлэл нийтлүүлэх	300
			Материал олшруулах, тараах	600
		Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	480
			Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480
Улсын бүртгэлийн ерөнхий газар	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: 20.2.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаад улсад санал өгсөн сонгогчдын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэж "гадаадад санал өгсөн" тэмдэглэгээг хийнэ.	Сонгогчдын мэдээллийг нэгтгэх	Гадаад улсад санал өгсөн сонгогчдын мэдээллийг (салбар комиссоос ирсэн эсвэл системээр дамжсан) улсын бүртгэлийн нэгдсэн санд төвлөрүүлэн нэгтгэх	700
		"Гадаадад санал өгсөн" тэмдэглэгээ сонгогч бүрээр хийх	Нэгдсэн санд байгаа тухайн иргэний бүртгэлд "гадаадад санал өгсөн" гэсэн тусгай тэмдэглэгээг программд оруулах	1
		Гадаадад санал өгсөн сонгогчийн ирцийн мэдээг бэлтгэх	Системд хийгдсэн тэмдэглэгээнүүдэд үндэслэн гадаадад санал өгсөн нийт сонгогчдын тоон мэдээг боловсруулах	1200
		Сонгогчийн ирцийн мэдээллийг СЕХ-нд хүргүүлж, нийтэд мэдээлэх	Мэдээллийг СЕХ-нд хүргүүлэх, нийтлүүлэх	300

	хуулийн 20.2-т заасны дагуу хийгдсэн тэмдэглэгээний мэдээлэлд үндэслэн гадаадад санал өгсөн сонгогчийн ирцийн мэдээллийг нэгтгэн гаргаж гадаадад санал авах ажиллагаа дууссанаас хойш хоёр хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлж, нийтэд мэдээлнэ			
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 60.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 60.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг хариуцна.	Сонгогчийг таниулах, бүртгэх	Сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах.	2
			Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг нягтлан шалгаж, бүртгэлийн хуудас олгох	2
Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комисс	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: 16 дугаар зүйлийн 16.8 Төв комисс нь сонгогчийн тоог үндэслэн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй газарт энэ хуульд нийцүүлэн салбар комисс байгуулж болно.	Судалгаа, төлөвлөлт хийх	ДТГ байрладаггүй хотууд дахь иргэдийн тооны судалгааг УБЕГ болон ГХЯ-наас гаргуулах.	960
			Сонгогчдын тоог үндэслэн салбар комисс байгуулах шаардлагатай байршлыг тогтоох.	480
		Салбар комисс байгуулах шийдвэр гаргах	Төв комиссоос (ГХЯ-ны дэргэдэх) салбар комисс байгуулах саналыг СЕХ-нд хүргүүлэх.	240
			Төв комиссоос салбар комиссын бүрэлдэхүүн, байршил, ажиллах хуваарийг батлах.	240
		Харилцаа холбоо ба ложистикийн үйл ажиллагааг зохион байгуулах	Санал авах байрны түрээсийн гэрээ байгуулах, харилцаа холбооны шугам сүлжээ, аюулгүй байдлыг хангах.	2400
	Санал тоолох төхөөрөмж, саналын хуудас, битүүмжилсэн хайрцаг	480		

			зэрэг техник хэрэгслийг хүргэх.		
		Хүний нөөцийг бэлтгэх, сургалт зохион байгуулах	Салбар комиссын гишүүдийг томилох, тэдгээрийг сонгуулийн хууль тогтоомж, техник хэрэгсэл ашиглах сургалтад хамруулах.	480	
		Мэдээлэл, сурталчилгаа	Тухайн бүс нутагт байгаа иргэдэд санал авах байрны байршил, цагийн хуваарийг мэдээлэх.	1440	
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл: 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн "Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон санал авах өдөр" гэснийг "энэ хуулийн 8.1-д заасны дагуу тогтоосон санал авах өдрөөс 13 хоногийн өмнө эхлүүлж тав хоногийн хугацаанд"	Өдөр бүрийн бэлтгэл хангах	Санал авах байрыг нээх, төхөөрөмжийг асаах, хяналтын хуудас хэвлэх.	300	
		Санал авах үйл ажиллагаа	Сонгогчийг таниулах, саналын хуудас олгох, санал уншуулах.	2	
		Өдрийн төгсгөлийн битүүмжлэл	Тухайн өдрийн санал хураалт дууссаны дараа төхөөрөмжийг түр зогсоож, саналын хайрцаг болон төхөөрөмжийг лацдаж, аюулгүй байдлыг хангах.	200	
		Нэгдсэн дүн гаргах	5 дахь өдрийн санал хураалт дууссаны дараа төхөөрөмжийн эцсийн дүнг хэвлэх, битүүмжлэх, СЕХ-нд дамжуулах.	120	
		Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 60.16.Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэгдсэн тухай тэмдэглэгээ хийнэ.	Сонгогчийн баримт бичгийг нягтлах	Иргэний үнэмлэхийн мэдээллийг системд уншуулах, тулгах.	1
Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн болон хэсгийн хороод		Биометрик танилт хийх	Сонгогчийн хурууны хээг уншуулж, нэрийн жагсаалттай тулгах.	2	
		Бүртгэлийн хуудас хэвлэх	Системээс бүртгэлийн хуудас хэвлэн гаргаж сонгогчид өгөх.	2	
		Системд тэмдэглэгээ хийх	Тухайн иргэнийг "бүртгэлийн хуудас авсан" гэж нэгдсэн санд төлөвийг өөрчлөх.	2	
		Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 61.6.гадаад улсад байгаа иргэдээс санал авах, тоолох, дүн дамжуулах ажиллагаанд сонгуулийн	Төхөөрөмжийн бэлтгэл	Санал тоолох төхөөрөмжийг асаах, хяналтын хуудас хэвлэх.	15
		Санал авах (Сканердах)	Сонгогч бөглөсөн саналын хуудсыг төхөөрөмжид уншуулах.	1	
		Дүн дамжуулах (E-transmission)	Санал хураалт дууссаны дараа дүнг битүүмжилсэн сувгаар төв серверт дамжуулах.	20	
		Тайлан хэвлэх	Хэсгийн хорооны дүнг цаасаар хэвлэж, баталгаажуулах.	20	

	автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр хэрэглэж болно.			
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг: 2.17.Сонгогч санал авах өдөр өөрийн харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн сонгуулийн хорооны дэргэд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр байгуулагдаж, энэ хуульд заасны дагуу бэлтгэсэн санал авах байранд саналаа өгч болно.	Сонгогчийг бүртгэх	Харьяа бус сонгогч ирсэн тохиолдолд иргэний бүртгэлийн мэдээллийг системд шалгах.	2
		Тусгай санал авах байранд санал авах	Сонгогчид тухайн байрны зориулалтын саналын хуудсыг олгож, санал авах.	2
		Мэдээлэл нэгтгэл	Харьяа бус газраас өгсөн саналын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэх.	2

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

### 3.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тоо /цаашид "тохиолдлын тоо" гэх/-г нэг ажилтанд шаардагдах нийт ажлын цагийн хамт тооцож гаргана. Тохиолдлын тоог тооцохдоо аргачлалын дагуу хэдэн байгууллага тухай үйл ажиллагааг гүйцэтгэхийг харгалзахаас гадна зарим үйл ажиллагаанд буюу сонгогчийг таниулах, саналын хуудас өгөх зэрэгт сонгогчдын тоог харгалзах шаардлагатай гэж үзэв (Хүснэгт 2).

#### Хүснэгт 2. Хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо (нэг жилд гүйцэтгэх тоо)	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Улсын Их Хурал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200	1	1200
		Мэдээлэл нийтлүүлэх	300	1	300
		Материал олшруулах, тараах	600	1	600

	46.1. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	480	1	480
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	1	480
Улсын бүртгэлийн ерөнхий газар	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: 20.2.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаад улсад санал өгсөн сонгогчдын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэж "гадаадад санал өгсөн" тэмдэглэгээг хийнэ.	Гадаад улсад санал өгсөн сонгогчдын мэдээллийг (салбар комиссоос ирсэн эсвэл системээр дамжсан) улсын бүртгэлийн нэгдсэн санд төвлөрүүлэн нэгтгэх	700	1	700
		Нэгдсэн санд байгаа тухайн иргэний бүртгэлд "гадаадад санал өгсөн" гэсэн тусгай тэмдэглэгээг програмд оруулах	1	96000 <sup>a</sup>	96000
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: 20.3.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.2-т заасны дагуу хийгдсэн тэмдэглэгээний мэдээлэлд үндэслэн гадаадад санал өгсөн сонгогчийн ирцийн мэдээллийг нэгтгэн гаргаж гадаадад санал	Системд хийгдсэн тэмдэглэгээнүүдэд үндэслэн гадаадад санал өгсөн нийт сонгогчдын тоон мэдээг боловсруулах	1200	1	1200
		Мэдээллийг СЕХ-нд хүргүүлэх, нийтлүүлэх	300	1	300

	авах ажиллагаа дууссанаас хойш хоёр хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлж, нийтэд мэдээлнэ				
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 60.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 60.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг хариуцна.	Сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах	2	96000	192000
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: 16 дугаар зүйлийн 16.8 Төв комисс нь сонгогчийн тоог үндэслэн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй гэж үзсэн энэ хуульд нийцүүлэн	Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг нягтлан шалгаж, бүртгэлийн хуудас олгох	2	96000	192000
Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комисс	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг: 16 дугаар зүйлийн 16.8 Төв комисс нь сонгогчийн тоог үндэслэн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй гэж үзсэн энэ хуульд нийцүүлэн	Дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй хотууд дахь иргэдийн тооны судалгааг УБЕГ болон ГХЯ-наас гаргуулах.	960	1	960
		Сонгогчдын тоог үндэслэн салбар комисс байгуулах шаардлагатай байршлыг тогтоох.	480	1	480
		Төв комиссоос (ГХЯ-ны дэргэдэх) салбар комисс байгуулах саналыг СЕХ-нд хүргүүлэх.	240	1	240

салбар комисс байгуулж болно.	СЕХ-ны тогтоолоор салбар комиссын бүрэлдэхүүн, байршил, ажиллах хуваарийг батлах.	240	1	240
	Санал авах байрны түрээсийн гэрээ байгуулах, харилцаа холбооны шугам сүлжээ, аюулгүй байдлыг хангах.	2400	9 <sup>b</sup>	21600
	Санал тоолох төхөөрөмж, саналын хуудас, битүүмжилсэн хайрцаг зэрэг техник хэрэгслийг хүргэх.	480	9	4320
	Салбар комиссын гишүүдийг томилох, тэдгээрийг сонгуулийн хууль тогтоомж, техник хэрэгсэл ашиглах сургалтад хамруулах.	480	36 <sup>c</sup>	17280
	Тухайн бүс-нутагт байгаа иргэдэд санал авах байрны байршил, цагийн хуваарийг мэдээлэх.	1440	9	12960
Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл: 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн "Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон санал авах өдөр" гэснийг "энэ хуулийн 8.1-д заасны дагуу тогтоосон санал	Санал авах байрыг нээх, төхөөрөмжийг асаах, хяналтын хуудас хэвлэх.	300	59 <sup>d</sup>	18000
	Сонгогчийг таниулах, саналын хуудас олгох, санал уншуулах.	2.	19200 <sup>e</sup>	38400
	Тухайн өдрийн санал хураалт дууссаны дараа төхөөрөмжийг түр зогсоож, саналын хайрцаг болон төхөөрөмжийг лацдаж, аюулгүй байдлыг хангах.	200	59	12000

	авах өдрөөс 13 хоногийн өмнө эхлүүлж тав хоногийн хугацаанд”	5 дахь өдрийн санал хураалт дууссаны дараа төхөөрөмжийн эцсийн дүнг хэвлэх, битүүмжлэх, СЕХ-нд дамжуулах.	120	59	7200
Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн болон хэсгийн хороод	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 60.16.Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэгдсэн тухай тэмдэглэгээ хийнэ.	Иргэний үнэмлэхийн мэдээллийг системд уншуулах, тулгах.	1	104000 <sup>f</sup>	104000
		Сонгогчийн хурууны хээг уншуулж, нэрийн жагсаалттай тулгах.	2	104000	208000
		Системээс бүртгэлийн хуудас хэвлэн гаргаж сонгогчид өгөх.	2	104000	208000
		Тухайн иргэнийг “бүртгэлийн хуудас авсан” гэж нэгдсэн санд төлөвийг өөрчлөх.	2	104000	208000
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 61.6.гадаад улсад байгаа иргэдээс санал авах, тоолох, дүн дамжуулах ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр хэрэглэж болно.	Санал тоолох төхөөрөмжийг асаах, хяналтын хуудас хэвлэх.	15	59	900
		Сонгогч бөглөсөн саналын хуудсыг төхөөрөмжид уншуулах.	1	27158 <sup>g</sup>	20000
		Санал хураалт дууссаны дараа дүнг битүүмжилсэн сувгаар төв серверт дамжуулах.	20	9	180
		Хэсгийн хорооны дүнг цаасаар хэвлэж, баталгаажуулах.	20	9	180
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг: 2.17.Сонгогч санал авах өдөр өөрийн харьяа хэсгийн хороонд	Харьяа бус сонгогч ирсэн тохиолдолд иргэний бүртгэлийн мэдээллийг системд шалгах.	2	104000	208000
		Сонгогчид тухайн байрны зориулалтын саналын хуудсыг олгож, санал авах.	2	104000	208000

саналаа өгөх боломжгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн сонгуулийн хорооны дэргэд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр байгуулагдаж, энэ хуульд заасны дагуу бэлтгэсэн санал авах байранд саналаа өгч болно.	Харьяа бус газраас өгсөн саналын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэх.	2	104000	208000
<b>НИЙТ</b>				<b>2,202,120.</b>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

<sup>a</sup> - Гадаад улсад байгаа нийт 120,000 сонгогчдын 80%

<sup>b</sup> – ДТГ байрладаггүй 2000-аас дээш сонгогчтой хотын тоо

<sup>c</sup> – ДТГ байрладаггүй хотод шинээр нээх Салбар комиссын ажилтны тоо (4 ажилтан х 9 хот)

<sup>d</sup> – ДТГ байрладаг болон байрладаггүй газрын Салбар комиссын нийлбэр

<sup>e</sup> – 96000 хүн/5 өдөр

<sup>f</sup> – Харьяа хэсгийн хороондоо сонгууль өгөх боломжгүй нийт 130,000 сонгогчдын 80%

<sup>g</sup> – ДТГ байрладаггүй газар сонгууль өгөх 33948 сонгогчдын 80%

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд үүссэн үүрэг, үйл ажиллагааг төрийн байгууллагууд хэрэгжүүлэхэд нийтдээ **2,202,120** минутын хүний нөөцийн хэрэгцээ үүсэхээр байна.

### 3.3. Нэмэгдэх ажлын ачаалал

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдрийн ердийн ажлын цагт үндэслэж нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнийг тооцно.

1 жил = ажлын 249 өдөр /Календарийн ажлын өдөр/

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хууль/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 249 ажлын өдөр буюу (249 x 8) 1992 цаг буюу (1992 x 60) **119,520 минут** ажиллана.

Эндээс төрийн байгууллагад нэмэгдэх ачааллын хэмжээг тооцохдоо аргачлалын 4.4.7-д заасны дагуу тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдаж байгаа хүний нөөцийн хэрэгцээг хугацаа (мин)-гаар илэрхийлснийг жилд шаардагдах ажлын цагийн хэмжээнд хувааж тооцов (Хүснэгт 3).

**Хүснэгт 3. Нэг жилд шаардагдах хугацаа ба нэмэгдэх ажлын ачаалал**

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ/мин/	Жилд шаардагдах ажлын цаг/мин/	Нэмэгдэх ажлын ачаалал
Улсын Их Хурал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1200	119520	0.01
		Мэдээлэл нийтлүүлэх	300	119520	0.003

		Материал олшруулах, тараах	600	119520	0.01
	46.1. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	480	119520	0.004
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	119520	0.004
Улсын бүртгэлийн ерөнхий газар	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: 20.2.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Гадаад улсад санал өгсөн сонгогчдын мэдээллийг (салбар комиссоос ирсэн эсвэл системээр дамжсан) улсын бүртгэлийн нэгдсэн санд төвлөрүүлэн нэгтгэх	700	119520	0.006
	гадаад улсад санал өгсөн сонгогчдын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэж "гадаадад санал өгсөн" тэмдэглэгээг хийнэ.	Нэгдсэн санд байгаа тухайн иргэний бүртгэлд "гадаадад санал өгсөн" гэсэн тусгай тэмдэглэгээг програмд оруулах	96000	119520	0.80
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:	Системд хийгдсэн тэмдэглэгээнүүдэд үндэслэн гадаадад санал өгсөн нийт сонгогчдын тоон мэдээг боловсруулах	1200	119520	0.01

	<p>20.3.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.2-т заасны дагуу хийгдсэн тэмдэглэгээний мэдээлэлд үндэслэн гадаадад санал өгсөн сонгогчийн ирцийн мэдээллийг нэгтгэн гаргаж гадаадад санал авах ажиллагаа дууссанаас хойш хоёр хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлж, нийтэд мэдээлнэ</p>	<p>Мэдээллийг СЕХ-нд хүргүүлэх, нийтлүүлэх</p>	<p>300</p>	<p>119520</p>	<p>0.003</p>
	<p>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 60.17.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 60.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг хариуцна.</p>	<p>Сонгогчийн гарын хурууны хээгээр сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах</p>	<p>192000</p>	<p>119520</p>	<p>1.61</p>
	<p>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:</p>	<p>Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг нягтлан шалгаж, бүртгэлийн хуудас олгох</p>	<p>192000</p>	<p>119520</p>	<p>1.61</p>
<p>Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон</p>	<p>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:</p>	<p>Дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй хотууд дахь иргэдийн тооны судалгааг УБЕГ болон ГХЯ-наас гаргуулах.</p>	<p>960</p>	<p>119520</p>	<p>0.01</p>

салбар комисс	16 дугаар зүйлийн 16.8 Төв комисс нь сонгогчийн тоог үндэслэн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй газарт энэ хуульд нийцүүлэн салбар комисс байгуулж болно.	Сонгогчдын тоог үндэслэн салбар комисс байгуулах шаардлагатай байршлыг тогтоох.	480	119520	0.004
		Төв комиссоос (ГХЯ-ны дэргэдэх) салбар комисс байгуулах саналыг СЕХ-нд хүргүүлэх.	240	119520	0.002
		СЕХ-ны тогтоолоор салбар комиссын бүрэлдэхүүн, байршил, ажиллах хуваарийг батлах.	240	119520	0.002
		Санал авах байрны түрээсийн гэрээ байгуулах, харилцаа холбооны шугам сүлжээ, аюулгүй байдлыг хангах.	21600	119520	0.18
		Санал тоолох төхөөрөмж, саналын хуудас, битүүмжилсэн хайрцаг зэрэг техник хэрэгслийг хүргэх.	4320	119520	0.04
		Салбар комиссын гишүүдийг томилох, тэдгээрийг сонгуулийн хууль тогтоомж, техник хэрэгсэл ашиглах сургалтад хамруулах.	19200	119520	0.16
		Тухайн бүс нутагт байгаа иргэдэд санал авах байрны байршил, цагийн хуваарийг мэдээлэх.	12960	119520	0.11
		Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл: 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн	Санал авах байрыг нээх, төхөөрөмжийг асаах, хяналтын хуудас хэвлэх.	18000	119520
	Сонгогчийг таниулах, саналын хуудас олгох, санал уншуулах.	38400	119520	0.32	

	“Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон санал авах гэснийг хуулийн 8.1-д заасны дагуу тогтоосон санал авах өдрөөс 13 хоногийн өмнө эхлүүлж <b>тав хоногийн хугацаанд</b> ”	Тухайн өдрийн санал хураалт дууссаны дараа төхөөрөмжийг түр зогсоож, саналын хайрцаг болон төхөөрөмжийг лацдаж, аюулгүй байдлыг хангах.	12000	119520	0.10
		5 дахь өдрийн санал хураалт дууссаны дараа төхөөрөмжийн эцсийн дүнг хэвлэх, битүүмжлэх, СЕХ-нд дамжуулах.	7200	119520	0.06
Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн болон хэсгийн хороод	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 60.16.Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд бүртгэгдсэн тухай тэмдэглэгээ хийнэ.	Иргэний үнэмлэхийн мэдээллийг системд уншуулах, тулгах.	104000	119520	0.87
		Сонгогчийн хурууны хээг уншуулж, нэрийн жагсаалттай тулгах.	208000	119520	1.74
		Системээс бүртгэлийн хуудас хэвлэн гаргаж сонгогчид өгөх.	208000	119520	1.74
		Тухайн иргэнийг "бүртгэлийн хуудас авсан" гэж нэгдсэн санд төлөвийг өөрчлөх.	208000	119520	1.74
	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг: 61.6.гадаад улсад байгаа иргэдээс санал авах, тоолох, дүн дамжуулах ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр хэрэглэж болно.	Санал тоолох төхөөрөмжийг асаах, хяналтын хуудас хэвлэх.	900	119520	0.01
		Сонгогч бөглөсөн саналын хуудсыг төхөөрөмжид уншуулах	20000	119520	0.17
		Санал хураалт дууссаны дараа дүнг битүүмжилсэн сувгаар төв серверт дамжуулах.	180	119520	0.002
		Хэсгийн хорооны дүнг цаасаар хэвлэж, баталгаажуулах.	180	119520	0.002

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг: 2.17. Сонгогч санал авах өдөр өөрийн харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн сонгуулийн хорооны дэргэд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр байгуулагдаж, энэ хуульд заасны дагуу бэлтгэсэн санал авах байранд саналаа өгч болно.	Харьяа бус сонгогч ирсэн тохиолдолд иргэний бүртгэлийн мэдээллийг системд шалгах.	208000	119520	1.74
	Сонгогчид тухайн байрны зориулалтын саналын хуудсыг олгож, санал авах.	208000	119520	1.74
	Харьяа бус газраас өгсөн саналын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэх.	208000	119520	1.74
<b>НИЙТ</b>		<b>2,202,120</b>		<b>18</b>

*Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туссан харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжгүй сонгогчид, дипломат төлөөлөгчийн газар (ДТГ) байрладаггүй хотын сонгогчдоос санал авах ажлыг зохион байгуулах, сонгуулийн санал авах төхөөрөмжийг гадаад улсад ашиглах зэрэг нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэхэд ойролцоогоор **2,202,120** мин зарцуулах шаардлагатай бөгөөд ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд нэмэгдэх ачааллыг ажилтны тоогоор илэрхийлбэл **18** байна.

### 3.4. Гарах зардлыг урьдчилан тооцох

Гарах зардлыг аргачлалын дагуу урьдчилан тооцохын тулд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр тооцно. Хүний нөөцийн зардлыг тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох цалин, нэмэгдэл, тусламж, төрөөс даадаг бусад бүх зардлыг нэгтгэн дунджаар тооцно. Хуулийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллагуудын цалин, нэмэгдлийн дундаж хэмжээ УИХ-ын Тамгын газар 5,752,002 төгрөг<sup>1</sup>, Сонгуулийн ерөнхий хороо 4,347,818<sup>2</sup> төгрөг, Улсын бүртгэлийн ерөнхий газар 2,187,791<sup>3</sup>, сонгуулийн хэсгийн хороо 982,080<sup>4</sup> төгрөг, салбар комисс 792,000 төгрөг байна. Иймд, төрөөс нэмж гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **274,384,868 (22,894,361\*12)** төгрөг байна гэж тооцов.<sup>5</sup>

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 239 дүгээр тогтоолын хавсралт

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

<sup>4</sup> СЕХ: ХХДХ+НДШ(24%)

<sup>5</sup> Шаардагдах хугацаа ба нэмэгдэх ажлын ачааллыг жилд ногдох хугацаа (буюу минут)-гаар тооцсон тул цалингийн зардлыг мөн 12 сараар тооцов.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын материаллаг зардлыг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) болон Гадаад харилцааны яам (ГХЯ)-наас ирүүлсэн сонгуулийн хэсгийн хорооны материаллаг зардал, гадаад улсад салбар комисс байгуулах зардал, сонгуулийн санал тоолох төхөөрөмжийн зардалд үндэслэн нэмэлтээр байгуулах салбар комиссууд, хэсгийн хороод, санал тоолох төхөөрөмжийн зардлыг ерөнхийлөн тооцлоо. Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн ДТГ байрладаггүй 2000-аас дээш сонгуулийн насны Монгол Улсын иргэд оршин суудаг гадаад улсын хотуудын талаар мэдээлэлд үндэслэн хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэгт Төв комисс нь сонгогчийн тоог үндэслэн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй газарт энэ хуульд нийцүүлэн салбар комисс байгуулж болно гэж заасны дагуу сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлбэл ойролцоогоор 9 хотод<sup>6</sup> шинээр салбар комисс байгуулахаар тооцов (Хүснэгт 4). Санал авах төхөөрөмжийн зардлыг тооцохдоо мөн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй газрын сонгогчид (~33,948)-ын тоо болон СЕХ-ноос ирүүлсэн 2024 оны УИХ-ын сонгуулиар нэг санал тоолох төхөөрөмжид ногдож байгаа сонгогчдын дундаж тоо (~580)-нд үндэслэн тооцсон болно.

**Хүснэгт 4. ДТГ байрладаггүй гадаад улс, хотод сонгууль зохион байгуулах салбар комисс байгуулах дундаж зардал**

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэгж дундаж зардал /төгрөгөөр/	Нийт зардал
Урсгал зардал	Ажилтан, албан хаагчид ногдох цалин, урамшуулал /4 ажилтан/	3,168,000.0	28,512,000.00
	Бичиг хэрэг	540,000.0	4,860,000.00
	Шуудан холбоо	720,000.0	6,480,000.00
	Санал авах байр бэлтгэх зардал	1,080,000.0	9,720,000.00
	Томилолт /саналын хуудас авах, буцааж хүргэх/	5,940,000.0	53,460,000.00
	Компьютер, тоног төхөөрөмж Тавилга, эд хогшил	0.0 0.0	- -
Хөрөнгө оруулалтын зардал	Төхөөрөмжийн үнэ	14,400,000.0	676,800,000 <sup>a</sup>
Үйл ажиллагааны зардал	Салбар комисст хүргүүлэх тээврийн дундаж зардал	675,000.0	6,075,000
	Түрээс	0.0	-
<b>НИЙТ</b>		<b>26,523,000.0</b>	<b>785,907,000</b>

Эх сурвалж: СЕХ, ГХЯ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн судлаач боловсруулав.

<sup>a</sup> –  $14,400,000 * (33948 * 80%) / 580$

Хуулийн төслийн дагуу дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй газарт салбар комисс байгуулахад нийт 33,948 орчим сонгогчдын 80 хувийг сонгууль өгнө гэж тооцвол нийтдээ 785,9 орчим сая төгрөг зарцуулах бөгөөд дийлэнх зардал буюу 86 хувь нь **санал тоолох төхөөрөмжийн зардал** байна.

<sup>6</sup> ГХЯ-наас ирүүлсэн тоон мэдээлэл

Мөн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсэгт Гадаад улсад байгаа иргэдээс санал авах, тоолох, дүн дамжуулах ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр хэрэглэж болно гэж заасныг хэрэгжүүлэхэд нийт 50 дипломат төлөөлөгчийн газрын<sup>7</sup> дэргэд байгуулагдах 50 салбар комисст шаардагдах санал тоолох төхөөрөмжийн үнэ, хүргэлтийн дундаж зардлын тооцоог Хүснэгт 5-д харууллаа.

**Хүснэгт 5. Салбар комисст санал тоолох төхөөрөмжийг ашиглах дундаж зардал**

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэгж/дундаж зардал /төгрөгөөр/	Нийт зардал
Хөрөнгө оруулалтын зардал	Төхөөрөмжийн үнэ	14,400,000	720,000,000
Үйл ажиллагааны зардал	Салбар комисст хүргүүлэх тээврийн дундаж зардал	675,000	33,750,000
<b>НИЙТ</b>		<b>15,075,000</b>	<b>753,750,000</b>

Эх сурвалж: СЕХ болон судлаачийн боловсруулснаар

Гадаад улсад сонгууль зохион байгуулах салбар комисст санал тоолох төхөөрөмжийг ашиглахад нийтдээ 1,4 (676,8 сая+6.1 сая+753,8 сая) орчим тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна.

Хуулийн төслийн 62 дугаар зүйлийн 62.17 дахь хэсэгт Сонгогч санал авах өдөр өөрийн харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжгүй тохиолдолд аймаг, сум, дүүргийн сонгуулийн хорооны дэргэд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр байгуулагдаж, энэ хуульд заасны дагуу бэлтгэсэн санал авах байранд саналаа өгч болно гэж заасны дагуу сонгуулийн хэсгийн хороо байгуулах материаллаг зардлын тооцоог Хүснэгт 6-д харууллаа.

**Хүснэгт 6. Сонгуулийн хэсгийн хорооны дундаж зардал**

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэгж/дундаж зардал /төгрөгөөр/	Нийт зардал
Урсгал зардал	Ажилтан, албан хаагчид ногдох цалин, урамшуулал /9 гишүүн, НДШ-тэй/	8,838,720.0	1,582,130,880.00
	Бичиг хэрэг	200,000.0	35,800,000.00
	Шуудан холбоо	250,000.0	44,750,000.00
	Унаа /зөөврийн хайрцгаар санал авах/	900,000.0	161,100,000.00
	Санал авах байр бэлтгэх	350,000.0	62,650,000.00
	Компьютер, тоног төхөөрөмж	0.0	-
	Тавилга, эд хогшил	0.0	-
ХО-тын зардал	Төхөөрөмжийн үнэ	14,400,000.0	2,577,600,000 <sup>a</sup>
ҮА-ны зардал	Түрээс	0.0	-
<b>НИЙТ</b>		<b>24,938,720</b>	<b>4,464,030,880</b>

Эх сурвалж: СЕХ, ГХЯ болон судлаачийн боловсруулснаар

Харьяа хэсгийн хороонд санал өгөх боломжгүй 130,000 орчим сонгогчдын 80 хувийн саналыг тусгайлан бэлтгэсэн байранд буюу нэмэлт хэсгийн хороонд авах ажлыг

<sup>7</sup> <https://www.gov.mn/mn/organization/mfa/service?documentId=1&serviceId=88ecae9e-8c58-4504-ab00-bcdf66cebc6f>

зохион байгуулахад ойролцоогоор 4,4 орчим тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна. Ийнхүү, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлснээр нэмж шаардагдах материаллаг зардал нийт 6,0 (785,9 сая+753,8 сая +4,5 тэрбум) орчим тэрбум төгрөг байна.

### 3.5. Нийт зардлыг тооцох

Нийт зардлыг тооцохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 4.6-д заасны дагуу өмнө тооцож гаргасан хүний нөөцийн зардлыг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж, материаллаг зардлыг нэмж тооцов (Хүснэгт 7).

#### Хүснэгт 7. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)	Бусад	Нийт
Төрийн байгууллага	18	274,384,868	6,003,687,880	-	6,278,072,748
<b>Нийт</b>					<b>6,278,072,748</b>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Уг хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр хуулийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллагууд, түүний албан хаагчдын хүний нөөцийн цалингийн зардалд жилд нийт 274,384,868 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 6,003,687,880 төгрөг, нийт 6,278,072,748 (~зургаан тэрбум хоёр зуун далан найман сая) төгрөгийн зардал үүсэхээр байна.

Дээрх зардлын улсын төсөвт ирэх ачааллыг төсвийн ерөнхийлөн захирагчаар 2026 оны батлагдсан урсгал зардалд үндэслэн 2027 оны төсөөллөөр тооцсоныг Хүснэгт 8-т харууллаа. Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчдад ногдох зардлыг тооцохдоо цалингийн болон материаллаг зардлыг тухайн төсвийн захирагчдад ногдох хэмжээгээр хуваарилж тооцсон болно.

#### Хүснэгт 8. Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчдын зардал, 2026-2027

Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч	2026 онд батлагдсан урсгал зардал /сая төг./	2027 онд нэмж шаардагдах хөрөнгө /сая төг./	2027 оны урсгал зардал /сая төг. төсөөлөл/
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	25,982.5	6,050.5 <sup>a</sup>	32,033.00
Гадаад харилцааны сайд	206,583.2	119.9 <sup>b</sup>	206,703.10
Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга	60,194.9	105.9 <sup>c</sup>	60,300.80
<b>НИЙТ</b>	<b>292,760.6</b>	<b>6,276.3</b>	<b>299,036.90</b>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Тайлбар: <sup>a</sup> – Материаллаг зардал (5,894,5 сая) + Хүний нөөцийн зардал (155,9 сая)

<sup>b</sup> – Материаллаг зардал (109,1 сая) + Хүний нөөцийн зардал (10,8 сая)

<sup>c</sup> – Материаллаг зардал (0 сая) + Хүний нөөцийн зардал (105,9 сая)

Аргачлалын 4.7-д заасны дагуу хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, давхардлыг арилгах, захиргааны ачааллыг багасгах боломжит хувилбаруудыг судалж үзэв.

Судалгаанд хуулийн төслийн гол зохицуулалт болох гадаад улсад урьдчилан бүртгэлгүй санал авах, 5 хоногийн хугацаанд урьдчилсан санал авах, харьяаллын бус хэсэгт санал авах, ДТГ байрладаггүй газар салбар комисс байгуулах, автоматжуулсан систем буюу санал тоолох төхөөрөмжийг гадаад улсад ашиглах үйл ажиллагааг хялбарчлах, нийт зардал 6,278,072,748 төгрөгийн зардал (хүний нөөц 274,4 сая, материаллаг 6.0 тэрбум)-ыг бууруулахад дараах хоёр боломжит хувилбарыг тодорхойлов:

1. Санал тоолох төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг оновчтой болгох буюу одоо байгаа 500<sup>8</sup> нөөц төхөөрөмжид багтаан зохион байгуулах боломжтой тул шинээр төхөөрөмж худалдаж авахгүй байх;

2. Захиргааны ачааллыг багасгах, төхөөрөмжийн тоог бууруулах үүднээс харьяаллын бус санал авах байрыг зөвхөн аймгийн төв, Улаанбаатарын томоохон дүүрэгт төвлөрүүлэх замаар үйл ажиллагааны зардлыг хэмнэх боломжтой;

Дээрх хувилбаруудыг хэрэгжүүлбэл 2027 оны нийт зардлыг 2.5-3.0 тэрбум төгрөгөөр хэмнэж, хуулийн төсөл батлагдсанаар үүсэх улсын төсвийн ачаалал ойролцоогоор 53 хувиар буурахаар байна.

---

<sup>8</sup> СЕХ-ны мэдээлэл

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэрэгжсэнээр иргэний сонгох эрхийг хэрэгжүүлэх боломж нэмэгдэж, өмнө нь зохион байгуулалтын бэрхшээлээс болж саналаа өгөх боломжгүй байсан 250,000 орчим иргэнд (гадаадад 120,000, улирлын ажилчид 56,000, оюутан 20,000, төрийн албан хаагчид 46,000, бусад 8,000) саналаа өгөх боломж нээгдэнэ. Энэ нь сонгуулийн ирц, ардчиллын чанарыг дээшлүүлэх, гадаадад байгаа монгол иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, харьяаллын бус нутаг дэвсгэрт байгаа иргэдийн эрхийг хангах зэрэг чухал нийгэм-эдийн засгийн үр дагавартай байна.

.Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн байгууллагад шинээр үүсэх үүрэг буюу ДТГ байрладаггүй газарт салбар комисс байгуулах, урьдчилсан санал авах, харьяаллын бус хэсгийн хороонд санал авах, гадаад улсад санал авах төхөөрөмж ашиглах зэрэг нь нийт 2,202,120 минутын хүний нөөцийн ачаалал (18 ажилтан), 274,4 сая төгрөгийн цалингийн зардал, 6,003,687,880 төгрөгийн материаллаг зардал үүсгэж, улсын төсвийн зарлагыг 2027 онд 6,278,072,748 төгрөгөөр нэмэгдүүлэхээр байна. Үүнээс 99.6% нь материаллаг зардал буюу тоног төхөөрөмж, байр, тээвэрлэлттэй холбоотой байна.

Аргачлалын 4.7-д заасны дагуу хийсэн хялбарчлах боломжийн судалгаагаар дээр дурдсан 2 үндсэн хувилбарыг хэрэгжүүлбэл (санал тоолох төхөөрөмжийн одоо байгаа нөөцийг ашиглах, харьяаллын бус газар санал авах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах) нийт зардлыг бууруулах бүрэн боломжтой байна. Энэ нь төсвийн дарамтыг ойролцоогоор 53 хувиар хөнгөлж, захиргааны ачааллыг багасгаж, давхардлыг арилгахад чиглэгдэж байна. Гэхдээ, одоо байгаа нөөцийг дараагийн сонгуулиудад ашиглахгүй тохиолдолд дээрх зардлын хэмжээг төсөвт тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай болно.

Энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын ардчиллын чанарыг дээшлүүлэх, иргэдийн эрхийг хангахад чиглэсэн чухал алхам болох бөгөөд хэрэгжүүлэх оновчтой арга хэмжээ авснаар төсвийн үр ашигтай байдлыг хангах боломжтой гэж дүгнэв.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- *Хууль тогтоомжийн тухай хууль (2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн);*
- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (шинэчилсэн найруулга) ;*
- *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” ;*
- *Сонгуулийн ерөнхий хорооны 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 3/98 тоот албан бичгээр ирүүлсэн 2024 оны сонгуулийн зардлын мэдээлэл, тоног төхөөрөмжийн үнэ;*
- *Гадаад харилцааны яамны 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 03/933 тоот албан бичгээр ирүүлсэн гадаадад байгаа иргэдийн тоо, байршлын мэдээлэл;*
- *Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгдсэн мэдээллийн сангийн статистик;*
- *Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль;*
- *Монгол Улсын Их Хурлын 2020 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*
- *Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралт*
- *Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт*
- *Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 239 дүгээр тогтоолын хавсралт*

ХАВСРАЛТ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ 2026 ОНЫ 02 ДУГААР САРЫН  
27-НЫ ӨДРИЙН 3/98 ТООТ АЛБАН БИЧГИЙН ХУУЛБАР

  
**МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО  
ТАМГЫН ГАЗАР**  
Засгийн газрын XI байр, Ж.Самбуурын гудамж 11,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141  
Утас: (976-51) 26 09 75  
Цахилгаан шуудан: gospr@gos.gov.mn  
Цахим хуудас: www.gos.gov.mn  
2026.02.27 № 3/98  
Талбай \_\_\_\_\_ Ид. № \_\_\_\_\_

ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНД

Танай 2026 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн  
ПС-01/0060 дугаар албан бичигтэй танилцаад Монгол  
Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг  
хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоолол  
гаргахад шаардлагатай мэдээллийг хавсралтаар  
хүргүүлж байна.



*2026.02.27*  
*Утасгүй*  
*3.07*  
*3/98*

*Д.Бат-Эрдэнэ*  
*2026.02.27*

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2023 оны 02 сарын 27-ны өдрийн 3/98 дугаар албан бичгийн хавсралт

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны холбогдох мэдээлэл

**Хүснэгт 1. Гадаад улсад сонгууль зохион байгуулах салбар комисс байгуулах дундаж зардал**

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэгж дундаж зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Нэг ажилтан, албан хаагчид ногдох цалин, урамшуулал /НДШ-тэй/	3,168,000.0
	Бичиг хэрэг	540,000.0
	Шүүдэн холбоо	720,000.0
	Санал авах байр бэлтгэх зардал	1,080,000.0
	Томилолт /саналын хуудас авах, буцааж	5,940,000.0
	Компьютер, тоног төхөөрөмж	0.0
Тавилга, эд хогшил	0.0	
ҮА-ны зардал	Түрээс	0.0
<b>Нэг салбар комисст ногдох нийт зардал</b>		<b>11,448,000.0</b>

**Хүснэгт 2. Сонгуулийн хэсгийн хорооны дундаж зардал**

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэгж дундаж зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Нэг ажилтан, албан хаагчид ногдох цалин, урамшуулал /НДШ-тэй/	8,838,720.0
	Бичиг хэрэг	200,000.0
	Шүүдэн холбоо	250,000.0
	Унаа /зөөврийн хайрцагар санал авах/	900,000.0
	Санал авах байр бэлтгэх	350,000.0
	Компьютер, тоног төхөөрөмж	0.0
Тавилга, эд хогшил	0.0	
ҮА-ны зардал	Түрээс	0.0
<b>Нэг хэсгийн хороонд ногдох нийт зардал</b>		<b>10,538,720.0</b>

**Хүснэгт 3. Сонгуулийн санал тоолох төхөөрөмжийн зардал**

Зардлын төрөл	Зардлын нэр	Нэгж дундаж зардал /төгрөгөөр/
ХО-тын зардал	Төхөөрөмжийн үнэ	14,400,000.0
ҮА-ны зардал	Салбар комисст хүргүүлэх тээврийн дунд	675,000.0
<b>Нэг төхөөрөмжид ногдох нийт зардал</b>		<b>15,075,000.0</b>

**Хүснэгт 4. Сонгуулийн санал тоолох төхөөрөмжид ногдох сонгогчдын тоо**

Байршил	Одоо ашиглаж байгаа төхөөрөмжийн тоо	2024 оны УИХ-ын сонгуулийн сонгогчдын тоо /санал өгсөн/	Нэг төхөөрөмжид ногдох сонгогчдын дундаж тоо /хүний тоо/
Монгол улсад	3000	1,450,037.0	580.01
Гадаад улсад	0	9,769.0	0
<b>НИЙТ</b>		<b>1,459,806.0</b>	

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ 2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН 02-  
НЫ ӨДРИЙН 03/933 ТООТ АЛБАН БИЧГИЙН ХУУЛБАР



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

Энхтайваны өргөн чөлөө 7а,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 25 21 35, Факс: (978-11) 32 21 27  
Цахим шуудан: info@mfa.gov.mn,  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2026.03.02 № 03/933  
танай 2026.2.28 -ны № ПС.01/0016-Т


Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоонд шаардлагатай холбогдох мэдээллийг нэгтгэн боловсруулсныг хүргүүлж байна.

Мөн 2027 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаас ирүүлсэн судалгааны мэдээллийг нэмэлтээр тусгав.

Хавсралт 2... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Л.МӨНХТҮШИГ

1197004

"Дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй 2000-аас дээш МУ-ын иргэд оршин суудаг гадаад улсын хотууд, сонгогчдын тоо"			
№	Гадаад улс	ДТГ газар байрладаггүй 2000-аас доошгүй МУ-ын иргэн оршин суудаг хот	Сонгуулийн насны иргэдийн тоо
1	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Дюссельдорф (Умард Райн-Вестфален муж улс)	1781 /бүх насны-2641/
2	Бүгд Найрамдах Солонгос Улс	Гёнги мужийн Инчон хот	11960 /бүх насны/
3		Өмнөд Чунчон мужийн Дэжён хот	2738 /бүх насны/
4	Америкийн Нэгдсэн Улс	Лос Анжелес	5000 орчим /бүх насны/
5		Сиатл	2000 орчим /бүх насны/
6		Денвер	3000 орчим /бүх насны/
7	Япон Улс	Сайтама	2737 /бүх насны/
8		Чиба	2749 /бүх насны/
9		Канагава	1983 /бүх насны/